

АТА КАРНЕЙН ФОРМ ЭЗЭМШИГЧИЙН БАТАЛГАА

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

.....-ийг (байгууллагын нэр) төлөөлж
.....(овог нэр бүтнээр бичих) миний бие үүгээр дараах
үүргүүдийг хүлээж,

аливаа зөрчил гаргавал манай байгууллага хариуцлагаа хүлээхээ үүгээр баталж байна. Үүнд:

1)Энэхүү АТА Карнейн формыг дагалдуулсан бараа бүтээгдэхүүнийг түр хугацаагаар нэвтрүүлсэн тухайн улсын гаалийн байгууллагаас тогтоосон хугацаа болон энэхүү АТА карнейн хүчинтэй хугацаанд багтаан тухайн улсын нутаг дэвсгэрээс шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлтийн хамт буцаан гаргаж, эх орондоо буцаан авчрахыг үүгээр баталж байна. Бараа бүтээгдэхүүнийг дурдсан хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэрээс буцаан гаргаагүй тохиолдолд холбогдох улсын гаалийн газарт зохих хариуцлагаа бүрэн хүлээн, төлбөл зохих гаалийн татвар болон бусад хураамжийг Монгол Улсын болон тухайн улсын гаалийн хууль, холбогдох журам, шаардлагын дагуу төлж барагдуулахаа үүгээр баталж байна.

2)Энэхүү баталгаа болон өргөдөлд дараах баримтуудыг хавсаргав:

а)АТА Карнейн хураамжид төлөгдсөн\$ ам.долларын баримт /МҮХАҮТанхимаас/

б)..... \$ ам.долларын (барьцааны) баталгааны баримт

в)..... \$ ам.долларын банкны баталгааны баримт

г)\$ ам.долларын өртөг бүхий бараа бүтээгдэхүүний даатгалын баримт /даатгалын үнийн дүн бүхий/

3)Дараах үүргүүдийг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөнө:

а)Дээр заасан барьцаа нь МҮХАҮТанхимаас олгосон АТА карнейг ашиглахад гаргасан аливаа зөрчил болон дээрх баримтыг буруу ашигласнаас үүдэн гарах гаалийн татвар болон бусад холбогдох хураамж, торгуулийг нөхөн төлөхөд ашиглагдана. Уг холбогдох хураамжийг нөхөн төлөхөд дутсан тохиолдолд АТА карней эзэмшигч нэмэлт төлбөрийг хариуцах үүрэгтэй.

б)Дээрх нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг МҮХАҮТанхим тайлбарын хамт хүргүүлсэн даруй заасан хугацаанд АТА Карней эзэмшигч нь бүр мөсөн төлж барагдуулна.

в)МҮХАҮТанхим нь 30 сарын дотор доорх нөхцлүүдийг харгалзан үзэж шаардлагатай гэж үзвэл төлбөл зохих төлбөрүүдийг хүчингүй болгох эрхтэй. Үүнд:

- АТА карнейн бүх маягтын шаардлагатай хуудсуудад, үүний дотор 1-ээр ногоон маягтад зохих гаалийн тэмдэглэгээг хийлгэж, тамгыг даруулсан байх

- Дээрх гаалийн тэмдэглэгээнд үндэслэн гаалиас тогтоосон нөхцлүүд болон хугацаанд бараа бүтээгдэхүүнийг буцаан гаргасан /ре-экспорт/ баталгаа гаргах, гаалийн байгууллагад үлдэх шар хуудасд /ре-экспорт/ эдгээр барааг үнэн зөвөөр мэдүүлж буцаан гаргаахаа үүгээр баталж байна гэсэн хэсэгт гарын үсгээ зурна.

- Мөн гаалийн тэмдэглэгээнд үндэслэн Монголын гаалиас тогтоосон нөхцөл болон заасан хугацаанд бараа бүтээгдэхүүнийг буцаан оруулсан нөхцөлд /ре-импорт/ баталгаа гаргах гаалийн байгууллагад үлдэх цагаан /ре-импорт/ хуудасд

эдгээр барааг үнэн зөвөөр мэдүүлж буцаан гаргааа үүгээр баталж байна гэсэн хэсэгт гарын үсгээ зурна.

- АТА Карнейн форм олгосон өдрөөс эхлэн ашиглах нөхцлүүд болон журмыг сахин мөрдсөн байх үүрэгтэй.

4) АТА Карнейн форм эзэмшигчийн баталгааны нөхцлүүдтэй танилцаж, хүлээн зөвшөөрч буйг үүгээр мэдэгдэж хавсаргасан бараа бүтээгдэхүүний жагсаалтад бичигдсэн мэдээлэл үнэн, зөв гэдгийг баталж байна.

5) Энэхүү баталгааг зөрчих, шаардлагын дагуу тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд барьцааны төлбөрийг 2 дахин нэмэгдүүлсэн торгууль хүлээнэ.

6) АТА Карнейн формыг ашиглаж дууссаны дараагаар эргүүлэн МҮХАҮТ-ын Үзэсгэлэн Яармагийн Газарт 1 сарын дотор буцааж өгнө.

7) Уг журмын 5-р заалтыг зөрчсөн болон 2 талын маргаан гарсан нөхцөлд МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитраар түүний хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

Гарын үсэгОгноо:

Хэрэглэгчийн албан тушаал, овог нэр

_____ /байгууллагын албан ёсны тамга/